



**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭН
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт “Инновэйшн Инвестмент” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх хэсэг 2026 оны 04 сарын 30-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Инновэйшн Инвестмент” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



А.БАТТАМИР



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин хянан нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторчуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

Инновэйшн Инвестмент ХК-ийн ТУЗ-өөс 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэхээр Мүүрь Аудит ХХК-г сонгож, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тус компаниар хөндлөнгийн аудитыг хийлгүүлсэн бөгөөд санхүү бүртгэл, санхүүгийн тайлагналын хувьд СТОУС-д нийцсэн, ямар нэг зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Энэ онд тус хороо нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулах үндсэн чиг үүргийнхээ дагуу улирал бүрийн санхүүгийн тайлантай танилцаж үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэн ажиллалаа. Аудитын хорооны хурлаар тус компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт хийхдээ хөндлөнгийн аудит хийсэн байгууллагын дүгнэлт, компанийн Санхүү удирдлагын газраас гаргуулсан мэдээ, мэдээллийг үндэслэл болгов.

Дүгнэх нь: Инновэйшн Инвестмент ХК нь үндсэн бизнесийн хувьд өөрийн охин компаниар дамжуулан бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд QPay үйлчилгээгээр хэрэглэгч, байгууллагуудад технологид суурилсан төлбөр тооцооны шийдлийг санал болгон ажиллаж байна. Тус системийн онцлог нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгодог давуу талтай билээ. 2025 онд Компанийн стратеги бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд амжилттай ажилласан байна.

2025 онд QPay мерчантуудад илүү анхаарал хандуулж, QPay-ээр төлбөр хүлээн авах идэвхийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх чиглэлээр зорилт тавьж ажилласан мөн цаашид тогтвортой өсөлтийг хангах үүднээс мерчант болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зах зээлд өрсөлдөхүйц шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийн суурийг амжилттай тавьсны үр дүнд 2025 онд QPay үйлчилгээгээр нийт 250.0 сая ширхэг гүйлгээ дамжсан бөгөөд энэ нь өмнөх оныхоос 42% -иар өссөн бол гүйлгээний үнийн дүнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад 54%-иар нэмэгдэж 16.3 их наяд төгрөгт хүрсэн байна.

Инновэйшн Инвестмент ХК нь нээлттэй хувьцаат компани болсоноос хойш Монголын төлбөр тооцооны зах зээлд өөрсдийн байр сууриа бэхжүүлж, өрсөлдөхүйц бүтээгдэхүүнүүдийг санал болгон амжилттай ажиллаж байна.

Үүний үр дүнд 2025 онд борлуулалтаа нэмэгдүүлэн 13.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Мөн 2024 оны жилийн цэвэр ашгаас нийт 7.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж байсан бол 2025 оны жилийн цэвэр ашгаас 9.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэснээр өөрийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өгөөжийг өсгөн ажилласан байна.

Иймд, Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос 2025 оны санхүүгийн үйл ажиллагааг хангалттай сайн гэж дүгнэж байна.

Иновэйшн Инвестмент ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ болон өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнасан болохыг танилцуулж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ